

## АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА 1	
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ .....	2
1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ.....	5
1.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого .....	6
1.2. Нэгдсэн төсвийн зарлага .....	7
1.3. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр.....	8
1.4. Төсвийн тусгай шаардлагыг хангасан байдал .....	10
1.5. Татварын зарлага .....	12
1.6. Худалдан авсан бараа, ажил үйлчилгээ .....	13
1.7. Нэмэлт төсөв .....	15
2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ .....	16
2.1. Улсын төсвийн орлого .....	16
2.2. Улсын төсвийн зарлага.....	17
2.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт .....	18
2.4. Засгийн газрын нөөц сан .....	22
3. ИРЭЭДҮЙН ӨВ САН.....	23
4.ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН .....	24
5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ .....	25
6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ .....	26
7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ .....	27
8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР .....	29
8.1. Засгийн газрын дотоод үнэт цаас .....	30
8.2. Засгийн газрын гадаад үнэт цаас.....	31
8.3. Засгийн газрын гадаад зээл .....	31
8.4. Засгийн газрын өрийн баталгаа.....	33
8.5. Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концесс .....	34
8.6. Дамжуулан зээл .....	35

## МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гарган, танилцуулж байна.

Танилцуулгад улсын төсвийн 31 ерөнхийлөн захирагчийн 1093 төсөвт байгууллага, нийслэл, дүүргүүд болон 21 аймгийн 3472 төсөвт байгууллагууд, Ирээдүйн өв сан, Тогтворжуулалтын сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангуудын төсвийн гүйцэтгэл хамрагдсан болно. Түүнчлэн төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланд татварын зарлагын тайлан, худалдан авсан ажил үйлчилгээний тайлан, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгийн танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл зэргийг нэгтгэн танилцуулж байна.

### **Төсөв, эдийн засгийн голлох үзүүлэлтүүд 2019 онд:**

- Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2019 онд 12,040.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.
- Төсөв, санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, төсвийг тодотгохгүйгээр мөрдүүлж, Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргахгүйгээр төсвийн санхүүжилтийг олгосон жил боллоо.
- Төсвийн тогтворжуулалтын санд 94.6 тэрбум, Ирээдүйн өв санд 1,040.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна.
- Засгийн газраас эдийн засгийг сэргээх, идэвхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд эдийн засгийн өсөлт 2019 онд 5.1 хувьд хүрлээ.
- Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 онд 13.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 6.7 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1,493.0 сая ам.долларын ашигтай гарсан байна.

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

**Эдийн засгийн өсөлт.** Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2019 онд урьдчилсан гүйцэтгэлээр 5.1 хувьд хүрлээ. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбар 8.4 хувиар, боловсруулах салбарын үйлдвэрлэл 11.0 хувиар, бөөний болон жижиглэн худалдаа 7.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2019 онд агшсан нь нийт эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн байна. Мөн үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа болон тээвэр ба агуулахын үйл ажиллагааны өсөлт нь өмнөх оноос буурсан байна.


**Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар**

	2015	2016	2017	2018	2019*
<b>Эдийн засгийн бодит өсөлт</b>	<b>2.4</b>	<b>1.2</b>	<b>5.3</b>	<b>7.2</b>	<b>5.1</b>
<i>Хөдөө аж ахуй</i>	<i>10.7</i>	<i>6.2</i>	<i>1.8</i>	<i>4.5</i>	<i>8.4</i>
<i>Уул уурхай</i>	<i>14.1</i>	<i>0.2</i>	<i>-5.5</i>	<i>6.1</i>	<i>-0.6</i>
<b>Боловсруулах аж үйлдвэр</b>	<b>2.6</b>	<b>-0.8</b>	<b>19.9</b>	<b>15.7</b>	<b>11.0</b>
<i>Барилга</i>	<i>-0.2</i>	<i>-4.9</i>	<i>11.4</i>	<i>4.7</i>	<i>5.8</i>
<b>Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ</b>	<b>-8.1</b>	<b>-2.6</b>	<b>6.8</b>	<b>2.2</b>	<b>7.2</b>
<b>Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа</b>	<b>5.1</b>	<b>11.5</b>	<b>14.2</b>	<b>7.6</b>	<b>3.2</b>
<b>Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа</b>	<b>14.6</b>	<b>2.3</b>	<b>9.1</b>	<b>5.5</b>	<b>10.3</b>
<b>Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа</b>	<b>4.3</b>	<b>1.2</b>	<b>6.7</b>	<b>6.9</b>	<b>1.9</b>

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо\* урьдчилсан гүйцэтгэл

**Инфляц.** Хэрэглээний үнийн индексээр тооцсон жилийн инфляц 2019 онд 5.2 хувь болж, өмнөх оноос 2.9 нэгж хувиар буурсан байна. 2018 онтой харьцуулахад нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлт бага байсан нь ерөнхий инфляцын түвшин буурахад голлон нөлөөлсөн байна.

**График 1. Инфляцын түвшин**




**Гадаад худалдаа.** Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 онд 13.7 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 6.7 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1493 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оноос 31.3 хувиар өссөн байна.

2019 онд экспортоор 7.6 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өмнөх оноос 8.7 хувиар өссөн байна. Уг өсөлтөд нүүрс, зэсийн баяжмал, жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортоор 6.1 тэрбум ам.долларын бараа, түүхий эд авсан нь 2018 оныхоос 4.3 хувиар өсжээ. Импортын өсөлтөд мал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл, дизелийн түлш, машин, механик тоног төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн, бүх төрлийн автомашины өсөлт голлон нөлөөлсөн байна.


**График 2. Гадаад худалдаа**



*Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо*

**Төлбөрийн тэнцэл.** Төлбөрийн тэнцэл 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 452.9 сая ам.долларын ашигтай гарлаа. Данснуудаар авч үзвэл, урсгал дансны алдагдал өнгөрсөн оноос 17.8 хувиар буурч, 1,813.0 сая ам.долларт хүрсэн бол хөрөнгө ба санхүүгийн данс 2,491.2 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар өссөн байна. Урсгал тэнцлийн алдагдал буурахад бараа, үйлчилгээний дансны алдагдал буурсан нь голлон нөлөөлсөн байна. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ 2019 онд өндөр байсантай холбоотойгоор манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүд болох чулуун нүүрс, боловсруулаагүй алт, төмрийн хүдрийн экспорт өссөн нь барааны дансны тэнцэл 1.5 тэрбум ам.долларын ашигтай гарахад голлон нөлөөлсөн байна.

**График 3. Төлбөрийн тэнцэл**




*Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо*

## 1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого анх удаа 2019 онд 12 их наяд төгрөгт хүрлээ. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 94.6 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 1,040.2 тэрбум төгрөгийг хуваарилж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 10,905.5 тэрбум төгрөг болсон. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 11,661.7 тэрбум байна. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь Дотоодын нийт бүтээгдэхүүн<sup>1</sup> - ий -2.0 хувьтай тэнцэж байна.

**График 4. Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт /2014- 2019 он, тэрбум төгрөг/**



**Тогтворжуулалтын сан.** Зэсийн зах зээлийн үнийн гүйцэтгэл 2019 оны ихэнх хугацаанд тэнцвэржүүлсэн үнээс доогуур байсан тул Төсвийн тогтворжуулалтын санд 94.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

**Ирээдүйн өв сан.** Ирээдүйн өв санд 2019 онд 1,068.5 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдсанаас 1,040.2 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөсөн хэмжээнээс 28.3 тэрбум төгрөгөөр буюу 2.6 хувиар дутуу төвлөрсөн байна. Тус санд төвлөрсөн орлогоос Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн дагуу улсын төсөвт 50.0 тэрбум төгрөгийг, Хүний хөгжил сангаас үлдсэн өрийн төлбөрт 466.3 тэрбум төгрөгийг тус тус шилжүүлсэн. Ингэснээр тус сангийн хуримтлал 636.7 тэрбум төгрөг байна.

<sup>1</sup> ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэл, оны үнээр – 36,897,640.2 сая төгрөг  
Эх сурвалж Үндэсний статистикийн хороо

## 1.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 онд 10,905.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 10.4 хувь буюу 1,023.5 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэлийг 2018 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,560.4 тэрбум төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 108.5 хувь, орон нутгийн төсвийн орлогын биелэлт 101.0 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын биелэлт 115.2 хувь, нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлт 112.5 хувь байна.

### Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн орлого / тэрбум төгрөг /

ҮЗҮҮЛЭЛТ	2019			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>11,272.5</b>	<b>12,040.3</b>	<b>106.8</b>	<b>767.8</b>
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	<b>322.0</b>	<b>94.6</b>	<b>29.4</b>	<b>(227.4)</b>
<b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>	<b>1,068.5</b>	<b>1,040.2</b>	<b>97.4</b>	<b>(28.3)</b>
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>9,882.0</b>	<b>10,905.5</b>	<b>110.4</b>	<b>1,023.5</b>
<b>1.Татварын орлого</b>	<b>8,694.5</b>	<b>9,813.2</b>	<b>112.9</b>	<b>1,118.7</b>
Орлогын албан татвар	2,114.1	2,555.7	120.9	441.6
Нийгмийн даатгалын орлого	1,687.5	2,030.5	120.3	343.1
Хөрөнгийн албан татвар	148.6	154.4	103.9	5.7
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,321.1	2,486.3	107.1	165.2
Онцгой албан татвар	837.8	863.4	103.1	25.6
Тусгай зориулалтын орлого	12.2	16.4	134.1	4.2
Гадаад үйл ажиллагааны орлого	743.0	790.2	106.3	47.2
Бусад татвар, төлбөр, хураамж	830.2	916.4	110.4	86.2
<b>2.Татварын бус орлого</b>	<b>1,187.4</b>	<b>1,092.3</b>	<b>92.0</b>	<b>(95.1)</b>

Тайлант онд татварын орлогын бүрдүүлэлт 9,813.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 1,118.7 тэрбум төгрөгөөр илүү буюу 12.9 хувиар давсан байна.

Татварын орлогын төрлүүдээс орлогын албан татвар 441.6 тэрбум, нийгмийн даатгалын орлого 343.1 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татвар 165.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давсан нь нийт татварын орлогын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн байна.

Монгол Улсын эдийн засаг дахин өсөлттэй гарч 2019 онд 5.1 хувьд хүрсэн, татварын албанаас татварын өр барагдуулах ажлыг эрчимжүүлж, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өмнөх оны дутуу төлөлт 251.1 тэрбум төгрөгийн татварын өрийг барагдуулсан нь орлогын албан татвар өсөхөд гол нөлөө үзүүлсэн байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийн үр дүнд татварын бүртгэл, хяналтын тогтолцоо эрс сайжирч, нэмэгдсэн өртгийн албан татварын нэгдсэн системд бүртгэгдсэн цахим төлбөрийн баримтын тоо 2019 оны байдлаар 464.0 саяд хүрч өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн, мөн бизнесийн идэвхжил нэмэгдэж, банкнуудын зээлийн өсөлт 2019 онд 5.0 хувиар өссөнөөр нийт эдийн засагт хэрэглээ өсөж, улмаар дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого өсөхөд нөлөөлжээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 860.6 сая, үүнээс экспорт 608.0 сая, импорт 252.6 сая ам.доллороор тус тус өссөн, мөн татвартай импорт 15.8 хувиар өсч, татвараас чөлөөлөгдсөн импорт 19.0 хувиар буурсан болон төгрөгийн ханшны сулралт 7.9% хүрч, төгрөгөөр илэрхийлсэн импортын дүн 12.1 хувиар нэмэгдсэн нь импортын барааны НӨАТ, онцгой татвар болон гадаад үйл ажиллагааны орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.

## 1.2. НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2019 онд 11,661.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 3.7 хувь буюу 444.8 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

### Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн зарлага/ тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2019		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>12,106.5</b>	<b>11,661.7</b>	<b>(444.8)</b>
<b>А. УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,532.2</b>	<b>8,228.6</b>	<b>(303.7)</b>
<b>1. Бараа, ажил үйлчилгээний зардал</b>	<b>4,170.2</b>	<b>4,000.5</b>	<b>(169.7)</b>
1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,282.4	2,257.0	(25.4)
2. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270.7	258.2	(12.5)
3. Хангамж, бараа материалын зардал	150.2	142.6	(7.6)
4. Нормативт зардал	305.4	299.8	(5.6)
5. Эд хогшил, урсгал засварын зардал	101.7	98.7	(2.9)
6. Томилт, зочны зардал	34.8	32.2	(2.6)
7. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	650.4	577.2	(73.2)
8. Бараа үйлчилгээний бусад зардал	374.6	334.7	(39.9)
<b>2. Хүү</b>	<b>865.6</b>	<b>861.0</b>	<b>(4.6)</b>
<b>3.Татаас</b>	<b>320.1</b>	<b>298.9</b>	<b>(21.2)</b>
<b>4. Урсгал шилжүүлэг</b>	<b>3,176.4</b>	<b>3,068.2</b>	<b>(108.1)</b>
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,405.5</b>	<b>3,016.7</b>	<b>(388.9)</b>
1. Барилга байгууламж	2,517.6	2,256.8	(260.8)
2. Их засвар	179.8	161.6	(18.1)
3. Тоног төхөөрөмж	261.2	244.0	(17.2)
4. Бусад хөрөнгө	426.2	334.7	(91.4)
5. Стратегийн нөөц хөрөнгө	20.9	19.6	(1.3)
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>168.7</b>	<b>416.4</b>	<b>247.7</b>



1. Эргэж төлөгдөх зээл	47.7	278.6	230.9
2. Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	121.0	137.8	16.8

Хөрөнгийн зардал 388.9 тэрбум, урсгал шилжүүлгийн зардал 108.1 тэрбум, бараа, ажил үйлчилгээний зардал 169.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан нь нийт зардлын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөв тус бүрээр ангилан харуулбал; улсын төсөв 98.8 хувийн гүйцэтгэлтэй буюу 111.5 тэрбум төгрөг дутуу зарцуулагдсан, Орон нутгийн төсөв төлөвлөсөн дүнгээс 9.3 хувь буюу 301.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв төлөвлөсөн дүнгээс 13.9 хувь буюу 56.7 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

#### Хүснэгт 4. Төсвүүдийн нийт зарлага ба цэвэр зээл / тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2019 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Нэгдсэн төсөв</b>	<b>12,106.5</b>	<b>11,661.7</b>	<b>(444.8)</b>
Улсын төсөв	9,406.6	9,295.1	(111.5)
Орон нутгийн төсөв	3,229.1	2,927.7	(301.4)
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	407.7	351.0	(56.7)
Нийгмийн даатгалын сангийн төсөв	2,068.5	2,062.3	(6.3)

### 1.3. НЭГДСЭН ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

#### Хүснэгт 5. Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл /тэрбум төгрөг/

Төсвийн бүрэлдэхүүн	2019 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>Нэгдсэн төсөв</b>	<b>-2,224.5</b>	<b>-756.2</b>	<b>1,468.4</b>
Улсын төсөв	-2,052.9	-1,317.5	735.4
Орон нутгийн төсөв	-311.9	19.9	331.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	0.0	118.7	118.7
Нийгмийн даатгалын сангийн төсөв	140.3	422.7	282.4

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,317.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, орон нутгийн төсвийн тэнцэл 19.9 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 118.7 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 422.7 тэрбум төгрөгийн ашигтай байна.

Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны эргэн төлөлтөд 165.1 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 438.3 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Ирээдүйн өв сангаас Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн дагуу 50.0 тэрбум, Хүний хөгжил сангаас үлдсэн өрийн төлбөрт 466.3 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт оруулсан.

2019 онд Төсвийн тогтворжуулалтын сангаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 9<sup>1</sup>.3.4-т заасны дагуу 322.0 тэрбум төгрөгийг тухайн жилийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсөвт шилжүүлсэн.

**Хүснэгт 6. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр/тэрбум төгрөг/**

Үзүүлэлт	Нэгдсэн төсөв	Улсын төсөв	Орон нутгийн төсөв	ЭМДС	НДС
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-756.2</b>	<b>-1,317.5</b>	<b>19.9</b>	<b>118.7</b>	<b>422.7</b>
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	756.2	1,317.5	-19.9	-118.7	-422.7
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-1,103.4	-541.5	-20.5	-118.7	-422.7
<b>ЗГ-ын бонд</b>	<b>-165.1</b>	<b>-165.1</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Урт хугацаат</b>	<b>-165.1</b>	<b>-165.1</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Дотоод</b>	<b>-165.1</b>	<b>-165.1</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Үндсэн төлбөр	-165.1	-165.1	0.0	0.0	0.0
<b>ЗГ-ын зээл</b>	<b>1,651.6</b>	<b>1,651.6</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>Дотоод</b>	<b>466.3</b>	<b>466.3</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Авлага	466.3	466.3	0.0	0.0	0.0
Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	466.3	466.3	0.0	0.0	0.0
<b>Гадаад</b>	<b>1,185.3</b>	<b>1,185.3</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Төслийн зээл	777.2	777.2	0.0	0.0	0.0
Шинээр авах	1,215.5	1,215.5	0.0	0.0	0.0
Үндсэн төлбөр	-438.3	-438.3	0.0	0.0	0.0
<b>Хөтөлбөрийн зээл</b>	<b>408.1</b>	<b>408.1</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
Шинээр авах	408.1	408.1	0.0	0.0	0.0
Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	50.0	50.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	322.0	322.0	0.0	0.0	0.0
Өмч хувьчлал	1.0	0.4	0.6	0.0	0.0

## 1.4. ТӨСВИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

**Төсвийн орлогын тусгай шаардлага:** Монгол Улсын 2019 оны төсвийн орлогын төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцох” тусгай шаардлагын дагуу боловсруулан батлуулж, төсвийн жилийн турш уг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан ажиллалаа.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т заасны дагуу гол нэр төрлийн эрдэс баялгийн 2019 онд баримтлах тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сан болон ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн төсөөлөл хийдэг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан өмнөх 20 жилийн үнийн дундаж болон тухайн төсвийн жил, түүний дараах 3 жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцсон.

Эрдэс бүтээгдэхүүний үнийн төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан зарчмын дагуу олон улсад нийтлэг хэрэглэдэг “Bloomberg” мэдээллийн эх сурвалжаас авч ашиглаж 2019 онд нэг тонн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6,222.2 ам.доллар, нүүрсний үнийг 76.0 ам.доллар байхаар тооцож, Төсвийн тогтворжуулалтын санд 322.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

### Хүснэгт 7. 2019 он зэсийн зах зээлийн үнэ

Бүтээгдэхүүний төрөл	Төлөвлөгөө	Тэнцвэр-жүүлсэн	Гүйцэтгэл	Зөрүү
Зэс, ам.доллар	6.272.2	6.222.2	6,004.6	267.6

Зэсийн зах зээлийн үнийн гүйцэтгэл 2019 оны ихэнх хугацаанд тэнцвэржүүлсэн үнэ буюу 6,222.2 ам.доллараас доош байсан тул Төсвийн тогтворжуулалтын санд төлөвлөсөн хэмжээнээс доош буюу 94.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

**Төсвийн тэнцлийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” гэж заасныг 2013 оны төсвийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн.

Улсын Их Хурлаас төсвийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-ийн тусгай шаардлагад 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд “Энэ хуулийн 6.1.2-т заасан нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 5.1 хувиас, 2021 онд 3.6 хувиас, 2022 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2023 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт

бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна.” гэж тусгасан.

#### Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл

		2019 он
1	Хуулиар тогтоосон хязгаар	-6.9%
2	Гүйцэтгэл	-2.0%

2019 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл -756.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -2.0 хувьтай тэнцэж байгаа нь тус шаардлагыг хангаж байна.

**Зарлагын өсөлтийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т “тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” гэж заасан.

#### Хүснэгт 9. Зарлагын өсөлтийн үзүүлэлтүүд

		2019 он
1	Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь	17.0%
2	Тухайн жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хувь	20.5%
3	Тухайн жилийн өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн дундаж	20.1%

**Өрийн тусгай шаардлага:** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг 2019 оны төсвийн жилд 75 хувиас хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан.

#### Хүснэгт 10. Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2019.12.31
I. Засгийн газрын дотоод өр		1,399.6
1.1	Үнэт цаас	1,399.6
II. Засгийн газрын гадаад өр		20,728.1
2.1	Үнэт цаас	7,927.2
2.2	Зээл	12,800.8
III. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэг		1,076.3
IV. Барих-шилжүүлэх концесс		995.7
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III+IV)		24,199.7
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		20,525.6
<b>Хуулиар тогтоосон өрийн хязгаар</b>		<b>75.0%</b>
<b>Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ</b>		<b>55.6%</b>

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2019 оны эцэст 24,199.7 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 20,525.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 55.6 хувьтай тэнцүү байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн тухай тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

## 1.5. ТАТВАРЫН ЗАРЛАГА

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-д “татварын зарлага” гэж татварын хуулиар тухайн жилд татвар төлөгчид олгох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэлнэ, мөн Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлд татварыг зөвхөн хуулиар бий болгох, тогтоох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй гэж тус тус заасан бөгөөд одоогийн байдлаар 240 гаруй төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн заалтууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 522.3 тэрбум төгрөг<sup>2</sup> буюу нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 4.8 хувьд хүрэхээр байна. Татварын зарлагын хэмжээг татвар, гаалийн байгууллагаар харуулбал дараах байдалтай байна.

### Хүснэгт 11. Татварын зарлагын хэмжээ/ тэрбум төгрөг/

Байгууллага	2019 он	Бүтэц хувиар
<b>Татварын байгууллага</b>	<b>307.5</b>	<b>58.9%</b>
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	53.8	10.3%
Хувь хүний орлогын албан татвар	178.6	34.2%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	75.1	14.4%
<b>Гаалийн байгууллага</b>	<b>214.9</b>	<b>41.1%</b>
Гаалийн албан татвар	27.5	5.3%
Онцгой албан татвар	125.1	24.0%
Нэмэгдсэн өртгийн албан татвар	62.2	11.9%
<b>Нийт татварын зарлага</b>	<b>522.3</b>	<b>100.0%</b>

Хүснэгтээс харахад нийт татварын зардал буюу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 58.9 хувь буюу 307.5 тэрбум төгрөгийг татварын алба, 41.1 хувь буюу 214.9 тэрбум төгрөгийг гаалийн байгууллага эдлүүлсэн байна.

<sup>2</sup> Сангийн сайдын 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 99 дугаар тушаалаар батлагдсан “Татварын зарлагад шинжилгээ хийх, гүйцэтгэлийг тайлагнах журам”-д заасны дагуу зарим төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын зарлагад хамруулахгүйгээр туссан бөгөөд журамд заасны дагуу татварын зарлагын гүйцэтгэлийн мэдээг гаргав..

## 1.6. ХУДАЛДАН АВСАН БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2019 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт 2,643.0 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

### Хүснэгт 12. Нийт худалдан авалтад тендер шалгаруулалтын журмыг хэрэглэсэн байдал/тэрбум төгрөг/

Д/д	Худалдан авалтын төрөл	Тендер шалгаруулалт зарласан тоо	Дүн	Хувь
1	Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар	3901	2,300.8	87.1
2	Шууд гэрээ байгуулах аргаар	586	177.5	6.7
3	Харьцуулалтын аргаар	4696	138.7	5.2
4	Шууд худалдан авалтаар	4501	19.3	0.7
5	Хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар	26	5.1	0.2
6	Олон нийтийн оролцооны аргаар	127	1.6	0.1
<b>Нийт худалдан авалт</b>		<b>13837</b>	<b>2,643.0</b>	<b>100.0</b>

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланд Сангийн сайдын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын 3 дугаар хавсралтад тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийлээ.

Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2019 онд нийт 3,103.0 /гурван их наяд нэг зуун гурав/ тэрбум төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, нийт 2,643.0 /хоёр их наяд зургаан зуун дөчин гурав/ тэрбум төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулж ажилласан байна. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх нийт 908 төсөл, арга хэмжээнд 1,037.7 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 942.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож гүйцэтгэл 90.7 хувьтай байсан болно. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны худалдан авах ажиллагаанд өгсөн үнэлгээний дүнгээр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Батлан хамгаалахын сайд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч, Шадар сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга нар 80-89 хувь буюу “Сайн”, Барилга, хот байгуулалтын сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд, Эрчим хүчний сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай

аймгийн Засаг дарга болон Нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын багц, Улсын Ерөнхий прокурор, Үндсэн хуулийн цэц, Үндэсний ерөнхий аудитор нар 60-79 хувь буюу "Хангалттай", Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Булган аймгийн Засаг дарга, Үндэсний статистикийн газрын дарга нар 40-59 хувь буюу "Хангалтгүй" үнэлгээ тус тус авсан байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногийн дотор хянан хариу өгөх үүрэгтэй байдаг. 2019 онд тендер шалгаруулалттай холбоотой нийт 1353 гомдол холбогдох байгууллагуудад гарсан байх бөгөөд үүнээс 219 гомдол буюу 16.2 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 1060 буюу 78.3 хувь нь захиалагчийн шийдвэрт, 74 буюу 5.5 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10<sup>1</sup> дугаар зүйл болон Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын 2-т заасан дотоодын үйлдвэрээс бараа худалдан авах заалтын хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн тайлангаас үзэхэд 2019 онд дотоодод үйлдвэрлэсэн 15 нэр, төрлийн бараанаас 151.9 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.



## 1.7. НЭМЭЛТ ТӨСӨВ

Нэмэлт төсөвт 2019 онд 625.1 тэрбум төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.

Нийт эх үүсвэрийн 246.6 тэрбум төгрөг буюу 39.4 хувь нь төсвийн эх үүсвэрээс, 378.5 тэрбум төгрөг буюу 60.6 хувь нь төсвийн бус эх үүсвэрээс санхүүжигдсэн байна. Эх үүсвэрийг ангилан үзэхэд:

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 162.4 тэрбум төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 65.8 тэрбум төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 312.7 тэрбум төгрөг;
- ЗГ-ын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 84.2 тэрбум төгрөг тус тус төвлөрсөн байна.

Нэмэлт төсвөөр 2019 онд 603.0 тэрбум төгрөг зарцуулагдсан байна. Үүнээс Батлан хамгаалахын сайдын зарлагын гүйцэтгэл 210.2 тэрбум төгрөг буюу нийт нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэлийн 34.9 хувь, Улаанбаатар хот 54.1 тэрбум төгрөг буюу нийт 9.0 хувь, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын зарлага 42.9 тэрбум төгрөг буюу 7.1 хувь, Эрүүл мэндийн сайдын гүйцэтгэл 27.6 тэрбум төгрөг буюу 4.6 хувь, Өмнөговь аймаг 25.8 тэрбум төгрөг буюу 4.3 хувь, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд 25.2 тэрбум төгрөг буюу 4.2 хувь, Хүнс хөдөө аж ахуйн сайд 23.6 тэрбум төгрөг буюу 3.9 хувийн гүйцэтгэл тус тус эзэлж байна.

Нэмэлт төсвийн нийт зарлагын 23.2 хувь буюу 139.8 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 22.2 хувь буюу 133.7 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт, 7.7 хувь буюу 46.9 тэрбум төгрөгийг томилолтын зардалд, 6.4 хувь буюу 38.8 тэрбум төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 5.0 хувь буюу 30,5 тэрбум төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд, 4.5 хувь буюу 27.1 тэрбум төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 2.1 хувь буюу 12.9 тэрбум төгрөгийг норматив зардалд тус тус зарцуулсан байна.



## 2. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ

Монгол Улсын төсөв нь нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн бөгөөд Монгол Улсын ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яамд болон тэдгээрийн харьяа байгууллагуудын бүрдүүлэн зарцуулах төсөв юм.

Монгол Улсын 2019 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 7,977.6 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 9,295.1 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 1,317.5 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

### 2.1. УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГО

Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2019 онд 7,977.6 тэрбум төгрөгт хүрч, 108.5 хувийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөгөөнөөс 623.9 тэрбум төгрөгөөр давсан, харин өмнөх оны гүйцэтгэлээс 1,149.2 тэрбум төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

#### Хүснэгт 13. Улсын төсвийн орлогын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	8,744.19	9,112.42	368.22
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	322.00	94.60	(227.40)
<b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>	1,068.52	1,040.22	(28.30)
<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	7,353.67	7,977.60	623.93
<b>Татварын орлого</b>	5,754.69	6,493.49	738.80
Орлогын албан татвар	1,240.00	1,660.57	420.57
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,321.10	2,486.27	165.17
Онцгой албан татвар	837.80	863.41	25.61
Тусгай зориулалтын орлого	12.20	16.36	4.16
Гадаад үйл ажиллагааны орлого	743.02	790.18	47.16
Бусад татвар, төлбөр, хураамж	600.57	676.71	76.14
<b>Татварын бус орлого</b>	1,598.98	1,484.11	(114.87)
Нийтлэг татварын бус орлого	840.16	793.78	(46.37)
Тусламжийн орлого	390.55	322.06	(68.50)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	368.27	368.27	-

Засгийн газраас төсвийн сахилга батыг сайжруулсан, эдийн засгийг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд эдийн засаг 2019 онд дахин эерэг өсөлт үзүүлж 5.1 хувьд хүрлээ. Эдийн засаг сэргэсэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа тогтворжсон болон төсвийн бодлогын чиглэлээр баримталсан арга хэмжээний үр дүнд 2019 онд Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 7,977.6 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 623.9 тэрбум төгрөгөөр илүү буюу 8.5 хувиар давсан байна.

Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 81.4 хувь татварын орлогоос, 18.6 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна.

Татварын орлогын төрлүүдээс орлогын албан татвар 420.6 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татвар 165.2 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс давсан нь нийт татварын орлогын гүйцэтгэлд голлон нөлөөлсөн байна.

## 2.2. УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Монгол Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2019 онд 9,295.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 111.5 тэрбум төгрөг буюу 1.2 хувиар бага гарсан байна.

Улсын төсвийн урсгал зардалд 6,353.5 тэрбум, хөрөнгийн зардалд 2,548.2 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд 393.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

### Хүснэгт 14. Улсын төсвийн зарлагын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	9,406.6	9,295.1	-111.5
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	9,278.5	8,901.6	-376.8
УРСГАЛ ЗАРДАЛ	6,537.8	6,353.5	-184.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,459.1	2,359.5	-99.6
ХҮҮ	865.6	861.0	-4.6
ТАТААС	714.3	705.8	-8.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,498.9	2,427.3	-71.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,740.7	2,548.2	-192.5
Дотоод эх үүсвэрээр	2,740.7	2,548.2	-192.5
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	128.1	393.5	265.3

Улсын төсвөөс Нийгмийн даатгалын санд 605.5 тэрбум төгрөгийн татаас, орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэгээр 161.0 тэрбум төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтэд 1,140.5 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн санд хуваарилах орлогын шилжүүлгээр 138.6 тэрбум төгрөгийг тус тус олгосон байна.

## 2.3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1293 төсөл, арга хэмжээний 1,698.2 тэрбум төгрөг батлагдсанаас, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1281 төсөл, арга хэмжээний 1,553.4 тэрбум төгрөг, “Барих-шилжүүлэх” нөхцөлтэй концессын гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлтөд 12 төсөл, арга хэмжээний 144.7 тэрбум төгрөг тус тус батлагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1281 төсөл, арга хэмжээнээс 908 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжиж, 373 төсөл, арга хэмжээ нь он дамжин хэрэгжсэн бөгөөд санхүүжилтийн гүйцэтгэл жилийн эцсийн байдлаар 1,560.4 тэрбум төгрөг буюу 91.9 хувийн биелэлттэй байна.

### Хүснэгт 15. Сүүлийн 7 жилийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл/тэрбум төгрөг/

№	Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	2013	1,174.3	789.1	67.2
2	2014	1,179.5	966.8	82.0
3	2015	357.9	246.4	68.8
4	2016	1,046.5	975.1	93.2
5	2017	779.3	714.8	91.7
6	2018	766.2	659.4	86.1
7	2019	1,698.3	1,560.4	91.9
<b>Нийт дүн</b>		<b>7,002.0</b>	<b>5,912.0</b>	<b>84.4</b> <i>/7 жилийн дундаж/</i>

Үүнээс, 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл дараах байдалтай байна.

**Хүснэгт 16. 2019 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөг/**

№	ТЕЗ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Нийт гүйцэтгэл	Үлдэгдэл санхүүжилт	Ашиглагдаагүй эх үүсвэрийн ангилал			Гүйцэтгэлийн хувь
						Тендерийн хэмнэлт	Ажлын гүйцэтгэл гараагүй	Гэрээ байгуулаагүй	
1	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	2,000.0	2,000.0	1,692.8	307.2	17.2		290.0	84.6%
2	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	37,231.2	14,231.2	13,762.2	469.0	469.0			96.7%
3	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	23,953.7	6,363.6	6,264.7	98.9	98.9			98.4%
4	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	62,536.8	38,714.0	35,034.0	3,680.0	1,780.0		1,900.0	90.5%
5	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	36,198.3	13,776.2	12,065.7	1,710.5	263.5		1,447.0	87.6%
6	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	2,875.0	2,875.0	2,866.9	8.1	8.1			99.7%
7	САНГИЙН САЙД	174,325.9	134,386.3	113,167.8	21,218.5	21,218.5			84.2%
8	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	83,851.4	42,883.4	42,730.8	152.6	152.4			99.6%
9	ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	59,472.7	33,895.4	29,456.3	4,439.1	1,489.0		2,950.0	86.9%
10	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	36,512.8	15,499.7	15,337.4	162.3	152.1	10.2		99.0%
11	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	347,368.3	141,350.1	138,491.0	2,859.2	1,359.6	1,499.5		98.0%
12	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД	1,165,862.1	616,453.8	558,983.9	57,470.0	20,406.8	8,171.1	28,891.4	90.7%
13	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	675,215.6	241,781.9	226,093.1	15,688.8	7,420.8	686.1	7,581.8	93.5%
14	УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД	2,000.0	2,000.0	-	2,000.0			2,000.0	0.0%
15	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	40,740.3	29,533.0	28,280.2	1,252.8	1,252.8			95.8%
16	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	200,690.9	97,150.3	86,227.9	10,922.4	4,851.7	2,120.8	3,950.0	88.8%
17	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	233,078.4	104,237.9	96,225.5	8,012.5	3,336.6		4,675.0	92.3%
18	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	820.0	820.0	820.0	-				100.0%
19	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	247.0	247.0	246.6	0.4	0.4			99.8%
20	ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	500.0	500.0	479.8	20.2	20.2			96.0%
21	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	4,690.4	4,400.4	4,226.2	174.2	174.2			96.0%
22	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	4,000.0	4,000.0	3,847.4	152.6	152.6			96.2%
23	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1,500.0	1,500.0	1,488.6	11.4	11.4			99.2%
24	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	800.0	800.0	797.2	2.8	2.8			99.7%
25	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	4,000.0	4,000.0	3,998.8	1.2	1.2			100.0%
<b>НИЙТ ДҮН</b>		<b>3,200,470.8</b>	<b>1,553,399.2</b>	<b>1,422,584.8</b>	<b>130,814.4</b>	<b>64,640.0</b>	<b>12,487.8</b>	<b>53,685.3</b>	<b>91.6%</b>

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд дараах барилга байгууламж ашиглалтад орсон. Үүнд:

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар:

- Цэцэрлэг 76,
- Сургуулийн барилга 46,
- Соёлын барилга байгууламж 22,
- Спорт заал 18,
- Дотуур байр 12,
- Спорт цогцолбор 1,
- Номын сан 1,

Эрүүл мэндийн салбар:

- Эмнэлгийн барилга 30,

Зам тээврийн салбар 22:

- Авто зам 63.6 км,
- Гүүрийн байгууламж 341.75 урт/метр,

Барилга хот байгуулалтын салбар:

- Инженерийн шугам сүлжээ 14,
- Гудамж талбайн гэрэлтүүлэг 3,
- Үерийн далан, байгууламж 1,
- Бусад 21,

Эрчим хүчний салбар:

- Цахилгаан дамжуулах шугам, дэд станц 100 (2000 км),
- Дулааны цахилгаан станц, дулааны шугам 10,

Хөдөө аж ахуйн салбар:

- Ахуй үйлчилгээний төвийн барилга 1 (397.5 м<sup>2</sup>),

Байгаль орчин, аялал жуулчлалын салбар:

- Соёл, спорт, амралт, аялал жуулчлалын цогцолбор 1,
- Цаг уурын станц 1,

Батлан хамгаалах салбар:

- Цэргийн сургалтын байр 1,
- Хичээлийн байр 1,
- Зэвсэгт хүчний ангийн автомашины граж 1,

Хууль зүйн салбар:

- Хилийн цэргийн ангийн барилга, байгууламж 5,
- Цагдаагийн хэлтсийн барилга 4,
- Улсын бүртгэлийн хэлтсийн барилга 1,
- Архивын хэлтсийн барилга 1,
- Дүүргийн мөрдөн байцаах газрын барилга 1,
- Шүүхийн шинжилгээний лабораторийн барилга 1,
- ХЗДХ-ийн салбарын нэгдсэн контор 1,

Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбар:

- ХХҮ-ний иргэдэд үйлчлэх төв 1,
- Гэр бүл, хүүхэд, ахмадын соёл амралтын цогцолборын барилга 1,

Мэргэжлийн хяналт, онцгой, стандартын салбар:

- Мэргэжлийн хяналтын лаборатори, контор 2,
- Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилга 1-ийг тус тус ашиглалтад оруулж хүлээлгэн өгсөн байна.

### **Концессын эргэн төлөлт:**

Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ барилга, байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалтаар концессын гэрээний дагуу 11 төсөл, арга хэмжээнд 144.7 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс аудитын дүгнэлтэд үндэслэн 137.4 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, гүйцэтгэл 94.9 хувьтай гарсан.

## 2.4. ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН

Монгол Улсын Засгийн газрын нөөц сангийн 2019 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлснээс гадна төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.3.1-д "Энэ хуулийн 6.1.2-т заасан эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх тусгай санд Засгийн газрын нөөц сан хамаарна" гэж заасны дагуу Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар Сангийн сайдын 2019 төсвийн багцад Засгийн газрын нөөц санг тусгасан. Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэлийг дараах хүснэгтэд харуулав.

### Хүснэгт 17. ЗГ-ын нөөц сангийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Дүн
2019 оны ЗГ-ын нөөц сангийн төлөвлөгөө	25.0
Засгийн газрын тогтоолын нийт дүн	28.3
Үүнээс: 2018 оны шийдвэр	0.9
2019 оны шийдвэр	27.4
Санхүүжүүлсэн нийт дүн	19.4
Санхүүжүүлээгүй дүн	-
Шийдвэрийн үлдэгдэл	8.9
Санхүүжүүлээгүй хүлээгдэж буй гүйцэтгэл	-

Засгийн газрын нөөц сангийн 2019 оны төлөвлөгөө 25.0 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 28.3 тэрбум төгрөгийг зарцуулахаар Засгийн газрын шийдвэрүүд гарсан байна. Засгийн газрын шийдвэрүүдийн дагуу нийт 19.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 77.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9<sup>1</sup>.2.3-т Засгийн газрын нөөц сангийн болон Эрсдэлийн сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй чөлөөт эх үүсвэр нь Төсвийн тогтворжуулалтын сангийн эх үүсвэр байхаар заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 5.6 тэрбум төгрөгийг тус санд төвлөрүүлсэн.

### 3. ИРЭЭДҮЙН ӨВ САН

Ирээдүйн өв сангийн тухай хууль 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлсэн. Ирээдүйн өв сангийн орлогын үндсэн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 65 хувь, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй эзэмшигч хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг юм.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д санд төвлөрүүлэх хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж батална гэж заасан бөгөөд тус санд 2019 онд 1,068.5 тэрбум төгрөг төвлөрөхөөр батлагдаж, гүйцэтгэл 1,040.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 28.3 тэрбум төгрөгөөр буюу 2.6 хувиар дутуу төвлөрсөн байна.

Ирээдүйн өв сан нь Хүний хөгжил сангийн боловсронгуй хэлбэр байхаар байгуулагдсан бөгөөд Хүний хөгжил санг Ирээдүйн өв санд шилжүүлж байгаатай холбоотойгоор Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг Улсын Их Хурлаас баталсан. Уг хуулийн дагуу Хүний хөгжил сангийн нийт 1,071.9 тэрбум төгрөгийн өр улсын төсөвт шилжиж, Ирээдүйн өв сангаас авах авлагаар бүртгэгдсэн. 2017 онд уг өр төлбөрөөс 196.9 тэрбум төгрөгийг, 2018 онд 408.7 тэрбум төгрөгийг барагдуулж, уг өрийн үлдэгдэл 466.3 тэрбум төгрөг болсон.

2019 онд тус санд төвлөрсөн орлогоос Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн дагуу улсын төсөвт 50.0 тэрбум төгрөгийг, Хүний хөгжил сангаас үлдсэн өрийн төлбөрт 466.3 тэрбум төгрөгийг тус тус шилжүүлсэн. Ингэснээр Ирээдүйн өв санд хуримтлал үүсэж эхэлсэн бөгөөд 2019 оны жилийн эцсийн байдлаар 636.7 тэрбум төгрөг байна.



#### 4.ТӨСВИЙН ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН

Төсвийн тогтворжуулалтын сан нь эдийн засгийн мөчлөг болон эрдэс, түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс шалтгаалсан төсвийн орлогын хэлбэлзлийг бууруулах, тогтворжуулах зорилготой баялгийн сан бөгөөд төсвийн алдагдлыг нөхөх зориулалтаар үнэ тогтвортой буюу өсөлттэй үед хуримтлуулдаг.

Уг санд 2011 оны 2 дугаар сараас хуримтлал бий болж эхэлсэн ба 2018 оны жилийн эцэст 311.4 тэрбум төгрөгийн хуримтлал байсан бөгөөд 2019 онд тус санд эрдэс баялгийн орлогоос 322.0 тэрбум төгрөг хуваарилагдахаар батлагдаж, гүйцэтгэл 94.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 70.6 хувиар буюу 227.4 тэрбум төгрөг дутуу төвлөрсөн байна. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 9<sup>1</sup>.2.3-т заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 5.7 тэрбум төгрөгийг тус санд төвлөрүүлсэн.

2019 онд Төсвийн тогтворжуулалтын сангаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9<sup>1</sup> дүгээр зүйлийн 9<sup>1</sup>.3.4-т заасны дагуу 322.0 тэрбум төгрөгийг тухайн жилийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор улсын төсөвт шилжүүлэн 2019 оны жилийн эцсийн байдлаар Төсвийн тогтворжуулалтын сан 89.7 тэрбум төгрөгийн хуримтлалтай байна.

## 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод 2019 онд эрүүл мэндийн даатгалын хураамжийн шимтгэлийн орлогоор 407.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 469.6 тэрбум төгрөг төвлөрч, 115.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

### Хүснэгт 18. ЭМДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	407.7	469.6	62.0
Татварын орлого	407.7	469.6	62.0
Нийгмийн даатгалын орлого	407.7	469.6	62.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	407.7	351.0	-56.7
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	407.7	351.0	-56.7
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5.3	4.5	-0.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2.0	1.9	-0.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.2	0.2	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.1	0.0	-0.1
Хангамж, бараа материалын зардал	0.2	0.2	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	0.7	0.5	-0.2
Томилолт, зочны зардал	0.2	0.1	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1.8	1.4	-0.4
Бараа үйлчилгээний бусад зардал	0.2	0.2	0.0
<b>ТАТААС</b>	51.5	40.5	-11.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	51.5	40.5	-11.0
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	350.8	306.0	-44.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	350.4	305.6	-44.8
Засгийн газрын дотоод шилжүүлэг	350.4	305.6	-44.8
Бусад урсгал шилжүүлэг	0.4	0.4	0.0
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	0.2	0.3	0.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	0.0	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.1	0.1	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	0.0
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	0.0	118.7	118.7
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.0	-118.7	-118.7
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0.0	-118.7	-118.7

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2019 онд 351.0 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 86.1 хувьтай тэнцэж байна. Ингэснээр Эрүүл мэндийн даатгалын сан нь 2019 онд 118.7 тэрбум төгрөгийн ашигтай байна.

## 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ

Нийгмийн даатгалын сангийн орлогод 2019 онд 2,208.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс 2,485.0 тэрбум төгрөг төвлөрч, 112.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлогуудаас нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийн төлбөрт 1,879.5 тэрбум төгрөг төвлөрч 117.2 хувийн биелэлттэй, улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 605.5 тэрбум төгрөгт хүрч 100 хувийн биелэлттэй байна.

### Хүснэгт 19. НДС-ийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,208.8</b>	<b>2,485.0</b>	<b>276.2</b>
<b>Татварын орлого</b>	<b>1,603.3</b>	<b>1,879.5</b>	<b>276.2</b>
Нийгмийн даатгалын орлого	1,603.3	1,879.5	276.2
<b>Татварын бус орлого</b>	<b>605.5</b>	<b>605.5</b>	<b>0.0</b>
Тусламжийн орлого	605.5	605.5	0.0
Хандив тусламж /дотоод/	605.5	605.5	0.0
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,068.5</b>	<b>2,062.3</b>	<b>-6.3</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,068.5</b>	<b>2,062.3</b>	<b>-6.3</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>23.9</b>	<b>23.4</b>	<b>-0.4</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16.7	16.7	-0.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2.0	2.0	0.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1.1	1.1	0.0
Хангамж, бараа материалын зардал	0.8	0.8	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	0.3	0.3	0.0
Томилолт, зочны зардал	0.2	0.2	0.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.4	2.1	-0.2
Бараа үйлчилгээний бусад зардал	0.4	0.3	-0.1
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,044.6</b>	<b>2,038.8</b>	<b>-5.8</b>
Бусад урсгал шилжүүлэг	2,044.6	2,038.8	-5.8
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	2,043.3	2,037.6	-5.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.3	0.3	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1.0	0.8	-0.1
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.0	0.0	0.0
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>140.3</b>	<b>422.7</b>	<b>282.4</b>
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-140.3	-422.7	-282.4
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-140.3	-422.7	-282.4

Харин нийгмийн даатгалын сангийн зарлага 2019 онд 2,062.3 тэрбум төгрөгт хүрч, нийт төлөвлөгөөний 99.7 хувьтай тэнцэж байна. Ингэснээр Нийгмийн даатгалын сан нь 2019 онд 422.7 тэрбум төгрөгийн ашигтай байна.

## 7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн 2019 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 2,947.6 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 1.0 хувь буюу 30.4 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Харин нийт зарлага 2,927.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 9.3 хувь буюу 301.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

### Хүснэгт 20. Орон нутгийн төсөв /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,917.2</b>	<b>2,947.6</b>	<b>30.4</b>
<b>Татварын орлого</b>	<b>1,252.4</b>	<b>1,289.2</b>	<b>36.8</b>
Орлогын албан татвар	874.1	895.2	21.1
Хөрөнгийн албан татвар	148.6	154.4	5.7
<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>229.6</b>	<b>239.7</b>	<b>10.0</b>
Бусад нийтлэг төлбөр, хураамж	78.6	61.8	-16.9
Газрын төлбөр	86.6	110.3	23.7
Байгалийн нөөц ашигласны төлбөр	56.3	59.0	2.6
Бусад татвар	8.0	8.6	0.6
<b>Татварын бус орлого</b>	<b>1,664.8</b>	<b>1,658.4</b>	<b>-6.4</b>
Нийтлэг татварын бус орлого	195.5	209.3	13.9
Хөрөнгийн орлого	1.3	0.8	-0.5
Тусламжийн орлого	13.2	8.1	-5.1
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,454.8	1,440.1	-14.7
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,229.1</b>	<b>2,927.7</b>	<b>-301.4</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,523.6</b>	<b>2,436.2</b>	<b>-87.4</b>
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,921.5	1,847.8	-73.7
ТАТААС	159.8	158.1	-1.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	442.4	430.3	-12.1
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>664.9</b>	<b>468.5</b>	<b>-196.4</b>
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>40.6</b>	<b>23.0</b>	<b>-17.6</b>
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-311.9</b>	<b>19.9</b>	<b>331.8</b>
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	311.9	-19.9	-331.8
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	261.7	-20.5	-282.2
<b>Өмч хувьчлал</b>	<b>50.2</b>	<b>0.6</b>	<b>-49.6</b>

Орон нутгийн орлогын 43.7 хувь татварын орлогоос, 56.3 хувь татварын бус орлогоос бүрдсэн байна. Татварын орлогын 69.4 хувь буюу 895.2 тэрбум төгрөг хувь хүний орлогын албан татвараар төвлөрсөн байна. Тайлант онд ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 37.9 тэрбум төгрөгийг олгосон байна. Бусад татвар, төлбөр, хураамжийн орлогоор 239.7 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Татварын бус орлогын 86.8 хувийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт /1,140.5 тэрбум/, улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг /161.0

тэрбум/, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг /138.6 тэрбум/ -ийн орлогууд бүрдүүлж байна.

Орон нутгийн нийт зарлага, санхүүжилтийн 83.2 хувь буюу 2,436.2 тэрбум төгрөгийг урсгал зардалд, үүнээс цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 1,161.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Хөрөнгийн зардлын гүйцэтгэл 468.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн дүнгээс 196.4 тэрбум төгрөгөөр бага байна. Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 368.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## 8. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 22,367.0 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д эзлэх хувь 58.9 хувьтай тэнцэж байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 24,199.7 тэрбум төгрөгт хүрч, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийг урьдчилсан ДНБ-д харьцуулсан харьцаа 55.6 хувьтай тэнцэж байна.

### Хүснэгт 21. Засгийн газрын өрийн үлдэгдэл, өрийн хэрэгслээр/тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ	2018.12.31	2019.12.31
I. Засгийн газрын дотоод өр	1,564.7	1,399.6
1.1 Үнэт цаас	1,564.7	1,399.6
II. Засгийн газрын гадаад өр	18,865.6	20,728.1
2.1 Үнэт цаас	7,664.5	7,927.2
2.2 Зээл	11,201.1	12,800.8
III. Засгийн газрын өрийн баталгаа	1,130.7	1,076.3
IV. Барих-шилжүүлэх концесс	806.0	995.7
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР</b>	<b>22,367.0</b>	<b>24,199.7</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)</b>	<b>18,955.9</b>	<b>20,525.6</b>
<b>Хуулиар тогтоосон өрийн хязгаар</b>	<b>80.0%</b>	<b>75.0%</b>
<b>Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ</b>	<b>58.9%</b>	<b>55.6%</b>
<b>Засгийн газрын өр / ДНБ</b>	<b>69.5%</b>	<b>65.6%</b>


Засгийн газрын нийт өрийн багцын 85.7 хувийг Засгийн газрын гадаад үнэт цаас болон зээл, 5.8 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаас, 4.4 хувийг Засгийн газрын өрийн баталгаа, 4.1 хувийг “барих-шилжүүлэх” төрлийн концессын өр төлбөр тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд Засгийн газрын гадаад өрийн үндсэн төлбөрт 438.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 708.8 тэрбум төгрөг, дотоод өрийн үндсэн төлбөрт 165.1 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 185.7 тэрбум төгрөг, нийт 603.5 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 894.5 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр тус тус төлөгдсөн.

## 8.1. ЗАСГИЙН ГАЗРЫН ДОТООД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 1,564.7 тэрбум төгрөг байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 1,399.6 тэрбум төгрөгт хүрч, 165.1 тэрбум төгрөгөөр буураад байна.

**График 5. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн мэдээлэл /тэрбум төгрөг/**



Дотоод үнэт цаасны үлдэгдэл буурсан гол шалтгаан нь Засгийн газрын зүгээс 2017 оны 10 дугаар сараас Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зогсоож 2018-2019 онд шинээр арилжаалаагүйтэй холбоотой.

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 947.6 тэрбум төгрөг буюу 67.7 хувийг улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гаргасан үнэт цаас, 374.0 тэрбум төгрөг буюу 26.7 хувийг Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас, 78.0 тэрбум төгрөг буюу 5.6 хувийг Хүний хөгжил сангийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гаргасан үнэт цаас тус тус эзэлж байна.

Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 165.1 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 185.7 тэрбум төгрөг, нийт 350.8 тэрбум төгрөгийг тус тус төлсөн. Үүнээс Улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 118.1 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 162.1 тэрбум төгрөг, Сайн хувьцаа хөтөлбөрийн үнэт цаасны хүүгийн төлбөрт 3.7 тэрбум төгрөг, Хүний хөгжил сангийн алдагдлыг нөхөх зорилгоор арилжаалсан үнэт цаасны үндсэн төлбөрт 47.0 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 19.9 тэрбум төгрөгийг тус тус төлсөн.

## 8.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ҮНЭТ ЦААС

Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2018 оны эцэст 7,664.5 тэрбум төгрөг байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар гадаад валютын ханшийн нөлөөгөөр Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 262.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 7,927.2 тэрбум төгрөгт хүрээд байна.

### Хүснэгт 22. Засгийн газрын гадаад бондын 2019 оны үлдэгдэл

№	Гадаад үнэт цаас	Валют	Гаргасан дүн	Гаргасан огноо	Купон	Хугацаа	Үлдэгдэл 2018.12.31	
							USD	MNT / Тэрбум төгрөг
1	Чингис-1,000.0	USD	1000\$	2012/12/05	5.125%	10	1,000.0	2,733.5
2	Мазаалай	USD	500\$	2016/04/06	10.875%	5	500.0	1,366.8
3	Хуралдай	USD	600\$	2017/03/09	8.750%	7	600.0	1,640.1
4	Гэрэгэ	USD	800\$	2017/10/26	5.625%	5.5	800.0	2,186.8
	НИЙТ						2,900.0	7,927.2

Тайлант хугацаанд Засгийн газрын гадаад үнэт цаас гаргаагүй бөгөөд хуваарийн дагуу 541.2 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдсөнөөс “Чингис” үнэт цаасны хүүгийн төлбөрт 137.6 тэрбум төгрөг, “Мазаалай” үнэт цаасны хүүгийн төлбөрт 144.1 тэрбум төгрөг, “Хуралдай” үнэт цаасны хүүгийн төлбөрт 139.3 тэрбум төгрөг, “Гэрэгэ” үнэт цаасны хүүгийн төлбөрт 120.2 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр тус тус төлөгдсөн.

## 8.3. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос эхлэн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны гишүүнээр элсэн орж олон талт болон хоёр талт зээлдүүлэгчдээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл, тусламж, техник туслалцааг авч ашиглаж ирсэн ба 1991-2019 он хүртэлх хугацаанд нийт 5.6 тэрбум ам.долларын гадаад зээлийг авч ашигласан байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2018 оны жилийн эцэст 11,201.1 тэрбум төгрөг байсан бол 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 12,800.8 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт өрийн багцын 52.9 хувийг эзэлж байна.



**Хүснэгт 23. Засгийн газрын гадаад зээлийн 2019 оны үлдэгдэл /тэрбум төгрөг/**

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл	Хувь
1	Арилжааны зээл	570.9	-	159.3	14.9	426.4	3.3%
2	Санхүүгийн зээл	602.0	-	27.4	17.9	592.5	4.6%
3	Төслийн зээл	7,410.6	1,230.5	215.9	268.7	8,693.8	67.9%
4	Хөтөлбөрийн зээл	2,617.7	408.1	35.7	98.0	3,088.1	24.1%
<b>НИЙТ</b>		<b>11,201.1</b>	<b>1,638.6</b>	<b>438.3</b>	<b>399.5</b>	<b>12,800.8</b>	<b>100%</b>

Олон улсын банк санхүүгийн байгууллага, түншлэгч орнуудын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй 82 төсөл, хөтөлбөрийн хүрээнд 2019 онд нийт 1,638.6 тэрбум төгрөгийг авч ашигласнаас 1,230.5 тэрбум төгрөгийг хэрэгжиж буй болон шинээр хэрэгжүүлж эхэлсэн 79 төслийн зээлийн хүрээнд, 408.1 тэрбум төгрөг нь ОУВС-ын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн 3-н хөтөлбөрийн хүрээнд тус тус зарцуулагдсан байна.

2019 онд хэрэгжиж буй гүйцэтгэл сайтай томоохон төсөл хөтөлбөрүүдээс дурдвал:

**Хүснэгт 24. Гадаад зээлийн эх үүсвэрийн ашиглалт / тэрбум төгрөг/**

<b>ТӨРӨЛ/ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН НЭР</b>		<b>Ашиглалт</b>
<b>I. ТӨСЛИЙН ЗЭЭЛ</b>		
Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх онгоцны буудал барих төсөл II		97.7
Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл		88.8
Улаанбаатар-Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам барих төсөл		85.8
Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл		56.3
Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, зам засварын төсөл II		52.8
Замын цагдаагийн газрын дэргэдэх уулзварт гүүрэн гарц байгуулах төсөл		48.8
Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км автозам барих төсөл		43.1
Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, хийн хоолой байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах төсөл		41.8

Монгол Улсын Засгийн газар гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж 2019 онд гадаад зээлийн үндсэн төлбөрт 438.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 167.5 тэрбум төгрөг, нийт 605.9 тэрбум төгрөгийг төлсөн.

## 8.4. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАТАЛГАА

Засгийн газрын баталгааны үлдэгдэл 2018 оны эцэст 1,130.7 тэрбум төгрөг байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 1,076.3 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 54.4 тэрбум төгрөгөөр буурсан. Үүнээс Монгол Улсын Хөгжлийн банкны баталгааны үлдэгдэл 972.6 тэрбум төгрөг, Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн баталгааны үлдэгдэл 79.4 тэрбум төгрөг, Эрдэнэс Монгол ХК-ний баталгааны үлдэгдэл 24.2 тэрбум төгрөг байна.

### Хүснэгт 25. Засгийн газрын өрийн баталгааны 2019 оны үлдэгдэл

#	Баталгааны дугаар	Зээлдүүлэгч	Валют	Зээллэгийн огноо	Баталгаа гаргуулагч	2018.12.31			
						үндсэн валют /сая/	Тэрбум төгрөг	Сая USD	
<b>I. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАРГАСАН</b>									
1	MIAT-1	PEFCO	USD	12/24/2013	МИАТ ХК	26.5	72.4	26.5	
2	MIAT-2	ING Capital	USD	12/24/2013	МИАТ ХК	2.6	7.0	2.6	
3	DBM-30	Japan Investors	JPY	1/6/2014	МУХБанк	30,000.0	751.2	274.8	
4	DBM-162	China Dev. bank	USD	9/3/2014	МУХБанк	81.0	221.4	81.0	
5	EM-35	ADB	USD	4/1/2016	Эрдэнэс Монгол ХХК	8.9	24.2	8.9	
<b>НИЙТ</b>							<b>1,076.3</b>	<b>393.7</b>	
<b>II. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСААР БАТАЛГААЖСАН</b>									
<b>1</b>	TDB-500 <sup>3</sup>	Олон улсын хөрөнгө оруулагч	USD	5/19/2015	ХХБ	500.0	1,366.8	500.0	

Худалдаа хөгжлийн банк нь эзэмшиж байсан **1.0** их наяд төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг барьцаалан баталгаа гаргуулсан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.3-т "Энэ хуулийн 6.1.4-т заасан Засгийн газрын өрийн хязгаарт Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг оруулж тооцохгүй." гэж заасны дагуу Засгийн газрын өрийн үлдэгдэлд оруулж тооцдоггүй бөгөөд барьцаат үнэт цаасны үлдэгдэл 2019 оны жилийн эцсийн байдлаар **946.1** тэрбум төгрөг байна.

<sup>3</sup> Засгийн газрын 2015 оны 163 дугаар тогтоолын дагуу Худалдаа хөгжлийн банкны 1.0 их наяд төгрөгийн дотоод үнэт цаасыг барьцаалан тус банкны олон улсын зах зээлд арилжаалсан 500.0 сая ам.долларын гадаад бондод өрийн баталгаа гаргасан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.3-т заасны дагуу Худалдаа хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасаар баталгаажсан өрийн баталгаа нь өрийн үлдэгдэлд тооцогдохгүй байх зохицуулалттай.

## 8.5. ТӨСВӨӨС ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ КОНЦЕСС

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт заасны дагуу улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдохоор хуульчилсан бөгөөд хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасны дагуу Сангийн яам Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Үндэсний хөгжлийн газар) болон орон нутгийн Засаг захиргааны байгууллагуудаас холбогдох журам, маягтад заасны дагуу улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч, нэгтгэн Засгийн газрын өрд бүртгэж байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2018 оны эцэст 806.0 тэрбум төгрөг байсан бол 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар 995.7 тэрбум төгрөг байна. Үүнээс Улсын төсвөөс эргэн төлөгдөх нийт 16 гэрээний үлдэгдэл 993.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нийт 7 гэрээний үлдэгдэл 2.2 тэрбум төгрөг байна.

### Хүснэгт 26: Барих-шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээний үлдэгдэл

Барих-шилжүүлэх Концесс	Төслийн тоо	Гэрээний дүн	Үлдэгдэл
<b>Улсын төсөв</b>	<b>16</b>	<b>1,624.3</b>	<b>993.5</b>
Гүйцэтгэл 100%	13	1,104.4	740.5
Гүйцэтгэл 95%	1	25.7	24.4
Гүйцэтгэл 41-43%	2	494.2	228.6
<b>Орон нутаг</b>	<b>7</b>	<b>8.3</b>	<b>2.2</b>
Баянхонгор аймаг	1	3.7	0.4
Говь-Алтай аймаг	3	3.5	1.3
Завхан аймаг	1	0.5	0.1
Ховд аймаг	2	0.6	0.4
<b>НИЙТ</b>	<b>23</b>	<b>1,632.6</b>	<b>995.7</b>

## 8.6. ДАМЖУУЛАН ЗЭЭЛ

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн үлдэгдэл 2018 оны эцэст 2,169.7 тэрбум төгрөг байсан бол 2019 онд 387.2 тэрбум төгрөгийг нэмж олгон, олгосон зээлийн эргэн төлөлтөд нийт 50.4 тэрбум төгрөгийн /үүнээс үндсэн төлбөрт 34.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 16.1 тэрбум төрөг/ орлогыг төсөвт төвлөрүүлж жилийн эцсийн гүйцэтгэлээр үлдэгдэл 2,663.2 тэрбум төгрөг байна. Тайлант хугацааны эцсийн валютын төгрөгийн ханш суларснаас шалтгаалан дамжуулан зээлийн үлдэгдэл 140.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

### Хүснэгт 27. Засгийн газрын гадаад зээлийн 2019 оны үлдэгдэл /тэрбум төгрөг/

№	Ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хорогдсон	Ханшийн зөрүү	Эцсийн үлдэгдэл	Хувь
1	ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	619.5	341.2	1.9	107.4	1,066.1	40%
2	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	998.4	15.5	20.2	22.0	1,015.6	38%
3	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	551.8	30.6	12.2	11.3	581.5	22%
<b>НИЙТ</b>		<b>2,169.7</b>	<b>387.2</b>	<b>34.3</b>	<b>140.7</b>	<b>2,663.2</b>	<b>100%</b>

--- o O o ---